



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 6/43

Чингис хот

Ажлаас чөлөөлж, түр орлон гүйцэтгэгч  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 23.5, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.2, 3.2.7, 4.2, 4.2.3, 4.4, 5.1, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн П.Пүрэвмаа өөр ажилд шилжин ажиллах болсон тул 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн томилогдох хүртэлх хугацаанд Хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Болоргэрэлийг албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

3. П.Пүрэвмаатай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д даалгасугай.

4. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ж.Гантулга	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Мөнгөнзул	-Соёлын үйл ажиллагаа, биеийн тамир спортын бодлого хариуцсан мэргэжилтэн
	Т.Баяртуяа	-Аж ахуйн нярав

ДАРГА



Ж.ГАНБААТАР